

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

Огноо: 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Ханбогдын дүүрэгт 2023 онд гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил

Тендер шалгаруулалтын дугаар: УУХҮЯ/202312010

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр Ханбогдын дүүрэгт 2023 онд гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил төслийг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах гэж байгаа тул уг үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг чадварын мэдүүлгээ ирүүлэхийг урь ж байна.

Тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тендер тул www.tender.gov.mn хаягаар мэдээллийг авч, мэдүүлгээ цахим системээр ирүүлнэ.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дор дурдсан нэр бүхий геологийн судалгааны ажил байна. Үүнд:

№	Төслийн нэр, байршил, аймаг, сумын нэр, код, (эхлэх, дуусах хугацаа,)	Геологийн даалгавар /шийдэх асуудал/
1	Ханбогдын дүүрэгт 2023 онд гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил. Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сум Код: Ханбогд-2023 Хугацаа: 2023	954.68 кв.км талбайн хэмжээнд дараах аргуудаас сонгож: - Геофизикийн цахилгаан хайгуул (high powered IP)-ын аргаар 1500 м хүртэл, хэтийн төлөв бүхий хэсгүүдэд 2000 м хүртэл гүнд, мөн дагалдах геофизикийн аргуудаар цогц хэмжилгүүдийг хийж, боловсруулах. - Агаарын болон газрын геофизикийн цогцолбор судалгаа (соронзон болон радиометр MagRad, хүндийн хүчний градиометр – GG, цахилгаан соронзон - EM). - Төрөл бүрийн чичирхийллийн судалгаа. Тухайн судалгааны ажлын үр дүн болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн болон бусад холбогдох материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, тектоник, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, геофизикийн хэмжилтийн үр дүн, түүнийг геологи-ашигт малтмалтын зүй тогтолтой уялдуулан хэтийн төлвийг үнэлж, тайлбар өгсөн дүгнэлт бүхий тайлангийн бичвэр, зургийг зохиох.

Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах материалуудыг баталгаажуулж ирүүлнэ. Үүнд:

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14, 15, 16 дугаар зүйлийн шаардлага хангасан тухай албан бичиг;

- Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй танилцуулга
- Хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- ШШГЕГ-ийн тодорхойлолт;
- Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй талаарх тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн 2021, 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт.
- Хуулийн этгээдийн тухайн чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл /сүүлийн 5 жилийн байдлаар/;
- Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд санал болгож буй мэргэжлийн боловсон хүчний нэрс, анкет /цээж зурагтай/, тэдгээрийн чадвар, туршлагын талаарх мэдээлэл, багийн бүрэлдэхүүнийг нотолсон баримт бичиг;
- Инженер техникийн ажилчдын сургууль төгссөн дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх;

Зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох бөгөөд оролцох сонирхолтой гадаадын хуулийн этгээд нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдтэй түншлэлийн хэлбэрээр оролцоно.

Ажлыг чанартай, шинэлэг аргаар гүйцэтгэх зорилгоор Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй түншлэн оролцох ба түншлэгч хуулийн этгээдийн туршлага, гүйцэтгэсэн төсөл, ажиллах хүний нэрсийг тодорхой ирүүлнэ.

Дараах мэдээллүүдийг ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны /tender.gov.mn/ цахим системээр дамжуулан шалгах болно. Үүнд:

- Татварын тодорхойлолт /тендер нээх үеийн байдлаар өр төлбөргүй байх/;
- Хуулийн этгээдийн 2021, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
- Нийгмийн даатгалын тодорхойлолт /тендер нээх үеийн байдлаар өр төлбөргүй байх/;
- Ажилтны сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт

Сонирхсон этгээд чадварын мэдүүлэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 17.00 цаг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 14:00 цагийн дотор www.tender.gov.mn цахим системээр ирүүлнэ үү.

Тендертэй холбоотой тодруулгыг хуульд заасан хугацааны дотор www.tender.gov.mn цахим систем болон 51-264883 утсаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Үнэлгээний хороонд хандан авч болно.

**Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо ,
Нэгдсэн үндэстний гудамж, Засгийн газрын 2-р байр, 310 тоот,
Утас: 51-264883 , Факс: 318169
Имэйл хаяг: info@mmhi.gov.mn
Веб хаяг: <http://mmhi.gov.mn>**